



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ



- Улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй
- Ардчилал ба улс төрийн институт
- Төрийн дотоод, гадаад бодлогын асуудлууд

VII

2011 № 348 (61)

ПОЛИТОЛОГИ VII

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ 348 (61)

Улаанбаатар хот,
Залуучуудын өргөн чөлөө
МУИС-ийн хичээлийн II байр
Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль,
Улс төр судлалын тэнхим
Орчин үеийн улс төрийн судалгааны төв

Утас: 7730-7730 (2306, 2324)

Факс: 976-11- 328890

©2011 CCPR



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХУДАЛДАА ҮЙЛДЭЭРЛЭЛИЙН СУРГУУЛИЙН
Хэвлэх үйлдвэр



УЛСТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОНОЛ, АРГА ЗҮЙ

Ё.Довчин доктор, тэргүүлэх профессор

МУИС, НШУС, Улстөр судлалын тэнхмийн эрхлэгч

Түлхүүр үг: “холимог засаглал”, Улстөрийн шинжлэх ухааны холбоо, позитив мэдлэг, норматив ба эмпирик онол, сэтгэл зүй-социологийн хандлага, “бихевориаль” хувьсгал, систем, соёл, модернизаци, неоинституционализм, онол-философийн хэмжүүр, плюрал зарчим

Товч агуулга: Эл өгүүлэлд улстөрийн шинжлэх ухаан ямар зам туулж хаана хэзээ үндэс суурь нь тавигдаж зохион байгуулалт, онол арга зүйн хувьд хэрхэн хөгжиж XX зуунд бие даасан шинжлэх ухаан, боловсрол мэдлэгийн салбар, мэргэшил болсныг авч үзсэн болно. “Холимог засаглал” хэмээх ойлголтыг тойрч улстөрийн олон онол, арга зүй хэрхэн хөгжиж өнөөдөр ямар төвшинд хүрсэн нь гол сэдэв юм.

Улстөрийг шинжлэх ухааны үүднээс судалсан үйл явцыг эрдэмтэн судлаачдын тэмдэглэснээр бүхэлд нь зураглан харуулбал тэр нь Грекийн улстөрийн сэтгэлгээнээс эх авч Ромын эзэнт улсын үед зарим ахицыг олж, гойдын дэвшил гаралгүй Дундад зууныг үдэж, Сэргэн мандал, Соён гэгээрүүлэлтийн үед бага зэрэг өөдөө өндийж, XIX зуунд мэдэгдэхүйц ололтууд гарч, улмаар XX зуунд баттай дэвжин хөгжиж улстөрийн шинжлэх ухаан мэдлэг ухааны бие даасан салбар болж, мэргэжлийн жишигт хүрсэн гэдэгтэй бид санал нийлэхээс аргагүй.

Улстөрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн замаар товч атугай ч аялая гэвэл эртний Грекээс эхлэх нь тодорхой. Тэр цагийн их гүн ухаантан Платон улстөрийн дэглэмүүдийг тоо, чанар талаас нь зургаан төрөлд ялган үзсэн нь зуун зууныг дамжсан үндсэн ангилал болж, мөн тэрбээр дэглэмүүд унаж доройтож, халагдаж солигдож байдаг зөрчилт үйл явцыг тогтоон барих арга нь “холимог засаглал” гэсэн санааг анхлан дэвшүүлж улмаар Аристотель тэрхүү ангилал, үзэл санааг үргэлжлүүлэн боловсруулсан нь засаглалыг хуваах онолын өвөг болсон ажээ. Аристотелийн арга Платоны идеалист онолоос эмпирик, түүхэн шинж чанараараа ялгарч байсан төдийгүй илүү тогтвортой байх магадлал бүхий “холимог засаглал”-ыг нийгмийн бүтэцтэй, тухайлбал дунд ангийн зонхилолтой холбон авч үзснээрээ онцлогтой байдаг. Платон, Аристотелийн үзэл санааг гүн ухаантан Полибий цаашид хөгжүүлж Ромын эзэнт гүрний хүчирхэгжилтийг холимог засаглалтай, тухайлбал, хаант, язгууртны, ард түмний засаглалын зарчмуудын хослол, Консулат, Сенат, Ассемблей нь тэдгээрийн биет цогцлол гэж үзсэн байна. Үүнээс нэлээд хожуу Цицерон Ромын түүхийг судлахдаа холимог засаглалын онолыг хэрэглэж, түрүү үеийн Ромын Бүгд найрамдах улсын улстөрийн бүтэц,

соёлыг эргэн сануулсны зэрэгцээ тэрбээр засаглалыг хүний рационал хийгээд нийгмийн уг чанартай холбон үзэж *байгалийн хуулийн* үзэл санааг хөгжүүлснээрээ нэр алдрыг олжээ.

Ийнхүү эртний Грек, Ромын үеийг туулсан төрийн засаглалын хэлбэр чухам ямар байх, тэдгээрийг хэрхэн үнэлж цэгнэх вэ гэсэн хоёр чухал асуултын нэгдэхэд нь Платон, Аристотелийн зургаан хэлбэрийн ангилал, мөн “холимог засаглал”, легитим шинж, шударга ёсыг хөндсөн үнэлэмжийн тухай хоёрдахь асуултад байгалийн хуулийн номлол хариу өгсөн байна.

Холимог засаглал, байгалийн хуулийн үзэл санаа Дундад зуун, Сэргэн мандалтын үед ч эерэг талаасаа үнэлэгдэж байсан төдийгүй тэр үеийн Италийн Венецийн хүч чадал, цэцэглэлтийг холимог тогтолцооны давуу талтай холбон үзэж байжээ. Энэ үеийн улстөрийн сэтгэлгээнд гэрэл цацруулсан содон үйл явдал бол улстөрийн дэглэмүүд, лидерүүдийн легитимийн тухай Маккиавеллийн онол байсан нь мэдээж. Түүний нэр хэдийгээр улстөрийн цинизмтэй холбогддог ч буруу, хэвийн бус дэглэмээс зайлах аргагүй, энэ бол бодит байдал гэснээр, өөрөөр хэлбэл улстөрийг тайлбарлах нь “үнэт зүйлсээс чөлөөтэй” зарчмыг зориглон гаргаж тавьснаар судлаачдын ярьдагаар улстөрийн шинжлэх ухааны мэдрэлийн гол судсыг тэмтэрч чаджээ.

Соён гэгээрүүлэлтийн үед улстөрийн сэтгэлгээнд мэдэгдэхүйц дэвшил гарчээ. Энэ үеийн улстөрийн сэтгэгчид Гоббс, Локк, Руссо, Монтескье, Медисон нар мөн л Платон, Аристотель, Полибий, Цицерон, Фома, Маккиавелли нартай ижил төсөөтэй сэдвүүдийг хөндөж байсан ч тэдний жам ёсны байдал, жам ёсны эрх, нийгмийн гэрээний онол нь социологи- сэтгэл зүйн дүгнэлтүүдэд тулгуурласан логик рационализмаар илүүтэй ялгарч байжээ гэж болох юм. Локк санааг нь тэрлэсэн засаглалыг хуваах онолыг Монтескье эмпирик харьцууллын үндсэн дээр цааш хол ахиулж засаглалын хамгийн төгс хэлбэр нь эрх мэдлийг хуваарилахад оршихыг нотолсон. Тэрбээр ард түмний, язгууртны, хааны засаглалыг хослуулсан холимог засаглалын загвар нь Английн төр гэж үзэж байв. Америкийн Үндсэн хуулийн эцгүүд Монтескьегийн онол ёсоор засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн салаа мөчрүүдэд хуваахын хамт эдгээрийг хооронд нь шүтэлцүүлэхийн тулд харилцан хяналт, тэнцвэрийн (checks and balances) зарчмыг улстөрийн практик туршлагаас авч хэрэглэжээ.

XIX, XX зууны улстөрийн сэтгэгчид Соён гэгээрүүлэлтийн уламжлалд түшиглэн улстөрийн хөгжил, өөрчлөлтийн үйл явц, түүний учир шалтгааныг түүхийн үүднээс нарийвчлан судалж, цаашдын чиг хандлагыг урьдчилан харах оролдлого хийснээрээ улстөрийн шинэ үзэл, онолыг шинжлэх ухааны эргэлтэд оруулж иржээ. Гегель түүхийг өөрийн диалектикаар авч үзэж туйлын санааны биелэлийг тодорхой төрийн засаглалын хэлбэр дээр буулган тайлбарласан бол түүний диалектик Марксын ангийн тэмцлийн болон формацийн онолын зарчим болж өгсөн байна. XIX зууны эхний хагасын том төлөөлөгч, позитивист философийг үндэслэгч А.Конт бүх шинжлэх ухаан хөгжлийн явцдаа теологийн ба метафизикийн хоёр шатыг дамжиж шинжлэх ухаан болсныг нотолж, энэхүү шинэ

шинжлэх ухааны социологи нь нийгмийн шинэтгэлийг бэлдэж өгсөн гэж үзэж байв. Үүний сацуу эдгээр хийсвэр онолуудын хариу болж улстөрийн институцийн формал-легаль судалгаа өргөн дэлгэрч байсныг дурдах хэрэгтэй. Мөн энэ зуунд түүхэн ба эмпирик арга зүйг хэрэглэн гүнзгий судалгаа хийж зохиол бүтээлээ туурвисан ардчиллын онолчид гэж нэрлэж болохоор Жон Стюарт Милл, Алексис де Токвиль нарын улстөрийн социологид үнэтэй хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэх ёстой. Ялангуяа ардчилал улстөрийн бусад дэглэмтэй өрсөлдөхүйц хувилбар байж чадах эсэх тухай эдгээр сэтгэгчид санаа зовинож байв.

XX зуун гарч Макс Вебер нийгмийн өөрчлөлтийг нийгмийн социаль бүтэц, соёлын учир холбогдлоор судалж, нийгмийн шинэчлэл, төрийн удирдлагын рациональ үндсийг онолын үүднээс тайлбарлаж, улстөрийг хариуцлагын ёс зүйтэй холбож мэргэшлийн хувьд үндэслэсэн нь улстөрийн социологид эргэлт болсон юм. Моска, Парето нар улстөрийн элитийн нийгэмд эзлэх байр, гүйцэтгэх үүргийг онолын үүднээс тайлбарлаж, Михельс, Острогорский нар ардчилсан нийгэмд олон түмний намууд бюрократчлагдснаас олигархи зайлшгүй үүсч болох ноцтой гэм согогийг олж харжээ. XX зууны эхэн үед европын улстөрийн онолыг америкийн улстөрийн шинжлэх ухаантай холбож өгсөн ойлголт бол "плюрализм" буюу "холимог засаглал"-ын хувилбарын тухай сэдэв байсныг судлаачид тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл плюрализмын нөхцөлд төр улсын бүрэн эрхийг хэмжээгүй эрхт хаант засаглалтай холбон үзсээр ирсэн үзэл баримтлал хатуу сорилттой тулгарсан болой. Үе үеийн сэтгэгчдийн үзэл сургаал, онол номлол өнгөрсөн зууны улстөрийн шинжлэх ухааны оюун санааны хөрс суурийг бүрдүүлж өгчээ.

Хэдийгээр улстөрийн шинжлэх ухааны оюун санааны өв уламжлалыг олон зуун жилээр тооцож болох ч уг шинжлэх ухаан өөрийн гэсэн судалгаа шинжилгээний арга, зарчим, зохион байгуулалтын бүтэц бүхий академик хийгээд боловсролын бие даасан мэдлэг ухааны салбар болон бүрэлдэж гарч ирсэн үе нь чухамдаа XX зуунтай холбоотой юм. Улстөрийн судалгааг дагнан эрхэлдэг анхны байгууллагууд (их сургуулийн факультетууд, улстөрийн судлагааны төвүүд) XIX зуунд Европт үүссэн ч дараачийн зуунд шинэ мэдлэг ухааны салбар зохион байгуулалтын хувьд бэхжих үйл явц улам хурдасчээ. Хэдийгээр дэлхийн нэгдүгээр дайн хүртэл улстөрийн онолын сэтгэлгээгээр Европ тэргүүлж байсан боловч улстөрийн шинжлэх ухааны зохион байгуултын бэхжилт Америкийн Нэгдсэн Улсад илүү эрчимтэй байв. Тухайлбал, энд тус салбарын үндэсний хэмжээний зохион байгуулалтын бүтэц анх бий болж, 1903 онд Америкийн Улстөрийн шинжлэх ухааны Холбоо байгуулагдан, олон тооны мэргэжлийн сэтгүүлүүд гарч, эрдэм шинжилгээний боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн байдаг. Тус холбоо дөнгөж 200 орчим гишүүнтэй үйл ажиллагаагаа эхэлж байсан бол одоо 13 мянгад хүрчээ. Иймд энэ үеэс 60-аад он хүртэл улстөр судлал бие даасан статусаа олж авах үйл явц хэрэг дээрээ америкийн нутаг дээр болжээ.

Дайны завсар Европт улстөрийн судалгаа үзэл суртал, суртал нэвтрүүлгийн эрх ашигт захирагдаж, тэнд фашист дэглэмүүд тогтносноос болж К.Дойч, П.Лазарсфельд, К.Мангейм, К.Моргентау, Л.Штраусс, З.Фрейд, Г.Маркузе г.м.

өрнөд европын олон эрдэмтэд далайн чанадад цагаачлахад хүрчээ. Энэ үйл явдал улстөрийн шинжлэх ухааны нэр хүндийг өргөж, энэ үед улстөр судлалаар Америк тэргүүлэх байр сууринд гарч ирэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна. Үүний сацуу АНУ-д улстөрийн судалгаа шинжилгээний ажил төрийн болон хувийн бизнесийн байгууллагуудаас өргөн дэмжлэг авч, юуны өмнө сонгогчдын үйл байдал, олон нийтийн санаа бодлоор судалгаа хийх төслүүдийг санхүүжүүлж эхэлсэн байдаг. Эдгээрийн үр дүнд улстөрийн судалгаа дагнан хийдэг байгууллагын тоо эрс нэмэгдсний зэрэгцээ дайны үеэр цэрэг, тагнуулын байгууллагууд өргөн хүрээтэй асуудлаар судалгааны ажлын захиалга өгч, нэртэй судлаачид, мэргэжилтнүүдийг татан оролцуулж байсан нь улстөрийн судалгаа шинжилгээ улам эрч хүчээ авахад чухал түлхэц болсон байна. Ийм нөхцөлд нийгмийн ухааны мэргэжилтнүүдийн хэрэгцээ өсч үүнийг дагаад судалгаа шинжилгээ, сургалтын байгууллагууд эрчимтэй хөгжжээ.

Дайны дараахь жилүүдэд АНУ-ын их сургуулиудад улстөрийн шинжлэх ухааны факультетуудын тоо огцом нэмэгдэж, улстөр судлаачдыг бэлтгэдэг олон улсын төвүүд болж хувирчээ. Эдгээрийн дотроос Мичиганы их сургууль Америкт болон гадаад орнуудад улстөрийн шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэхэд үндсэн гол үүрэг гүйцэтгэжээ. Чикагогийн их сургуулийн Улстөрийн шинжлэх ухааны сургууль улстөрийн судлалд шинжлэх ухааны хувьсгалын очыг бадраасан бол Мичиганы их сургуулийн Нийгмийн судалгааны институт шинжлэх ухааныг судлах сурталчлах үйлсийг манлайлсан ажээ.

Америкийн жишээгээр 1949 онд Олон улсын улстөрийн шинжлэх ухааны холбоо байгуулагдснаас хойш улстөрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үр бүтээлтэй үйл ажиллагаа дэлхийн хэмжээнд идэвхжиж, уг холбоо өнөөдөр 3700 гаруй гишүүнтэй болж, 3 жил тутам улстөрийн шинжлэх ухааны Дэлхийн Их хурлыг хуралдуулж, сүүлийн XXI их хурал 2010 онд Чилийн Сантьяго хотод болж өнгөрөв. Дайны дараа америкийн улстөрийн шинжлэх ухааны жишиг, зарчмуудыг европын хөрсөнд буулгах ажлууд хийгдэж, 1960-аад он гэхэд хуучин европын их сургуулиуд бүрэн сэргэж, олон тооны улстөрийн сургалт судалгааны төвүүд байгуулагдах болжээ. Энэ үеэс европын улстөр судлаачдын тоо байнга өсч 1980-аад оны дунд гэхэд европын улстөрийн шинжлэх ухааны эрдэмтдийн тоо 2500-аас давж, тэдний улстөрийн шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр улам бүр жинтэй болсоор байгаа нь илэрхий байна.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Америкийн Нэгдсэн Улсад улстөрийн судалгааны төслүүдийг санхүүжүүлэх, зохион байгуултын талаас дэмжих бие даасан байгууллагууд бий болжээ. Жишээ нь, Америкийн Сонгуулийн судалгааны үндэсний хороо (ANES), Нийгмийн шинжлэх ухааны судалгааны Зөвлөлийг (SSRC) дурдаж болох бөгөөд тэдгээр нь залуу судлаачдад тэтгэлэг олгож, тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж иржээ. Ялангуяа түүний хоёр хороо-Улстөрийн үйл байдлын хороо, Харьцуулсан улстөрийн хороо сонгууль судлал, улстөрийн судалгааны шинэ шинэ арга зүйг эрэлхийлэх талаар ихээхэн идэвх гаргаж ажиллажээ. Жишээ нь, харьцуулсан улстөрийн хөтөлбөрт америкийн

эрдэмтдээс гадна тавны нэг нь гадаадын судлаачид оролцож байв. Тэдний дотор Европт улстөрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх хөдөлгөөний лидерүүд С.Роккан, Х.Даалдер, С.Файнер, Р.Рооз, Ж.Сартори нар байв. 1961 онд хэд хэдэн их сургуулийн санаачилгаар Улстөр, нийгмийн судалгааны их сургуулиуд хоорондын Консорциумыг (ICPSR) байгуулагдаж, олон талт судалгаа шинжилгээний явцад улстөр судлаачдын цуглуулж хуримтлуулсан тоон мэдээллийг агуулсан нэн баялаг архивын сан хөмрөгийг бий болгосон нь улстөрийн судалгаанд нэн үнэ цэнэтэй эх сурвалж болжээ. 1971 онд энэ жишээгээр 140 гаруй гишүүнтэй байгуулагдсан Улстөр, нийгмийн судалгааны Европын Консорциум улстөр судлалын сургалт зохион байгуулах, улстөрийн судалгааны хамтарсан төслүүд хэрэгжүүлэх, үндэсний улстөрийн судалгааны төвүүд байгуулах зэрэг ажлыг уялдуулан зохицуулж санхүүжүүлдэг байна. Мөн мэргэжлийн тогтмол сэтгүүл “Улстөрийн судалгааны Европын сэтгүүл” хэвлэгдэж, нийтлэл нь Европын дайны дараахь улстөрийн шинжлэх ухааны түүхийн асуудлуудыг өргөн тусгах болжээ. Мөн Европын улстөрийн шинжлэх ухааны дэвшил нь юуны өмнө ардчиллах үйл явцтай шууд холбоотой байсны сацуу нээлттэй, идэвхтэй нийгмийн хамгааллын төр гарч ирсэн нь улстөрийн үйл явц, улстөрийн үйл ажиллагааны талаар асар их мэдээлэл шаардаж байсан нь бас нөлөөлсөн байна.

Ийнхүү 70-90-ээд онд улстөрийн шинжлэх ухаан боловсрол, судалгаа шинжилгээний байгууллагуудын өргөн тогтолцоо, ерөнхий зохицуулах төв - Олон улсын улстөрийн шинжлэх ухааны холбоо, хэдэн арваар тоологдох мэргэжлийн тогтмол хэвлэлүүд бүхий зохион байгуулалтын бүтэцтэй нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн академик салбар ухаан болж хөгжиж чаджээ.

Улстөрийн шинжлэх ухаан мэдлэг ухааны бие даасан салбар болж үүсэхдээ философи, түүх, социологи, хууль зүй, эдийн засаг, сэтгэл судлал зэрэг бусад салбар ухаануудаас судлагдхуун, агуулга талаас төдийгүй арга зүйн хувьд заагран тусгаарласан юм. Энэхүү арга зүйн онцлог нь улстөрийн судалгаа шинжилгээ тууштай шинжлэх ухаанч шинж чанарыг шаардах ёстой гэдэгт оршиж байв. Шинжлэх ухаанч чанар гэдгийг судалгаа шинжилгээ, зөвхөн туршлагын замаар нотлогдсон баримтуудад тулгуурлаж, үүний үндсэн дээр логикийн дүрмийн дагуу дүгнэлтүүд хийгдэх учиртай гэсэн позитивист утгаар ойлгож байв. Улстөрийн үзэгдэлд чингэж дүн шинжилгээ хийх нь улстөр судлаачид субъектив үнэлгээнээс зайлсхийх боломжтой. Энэ тохиолдолд улстөрийн шинжлэх ухаанд байгалийн ухаан үлгэр загвар болох бөгөөд шинжлэх ухаанч байхын цогц биелэл нь аливаа субъективизмээс хол хөндий байдаг математик байх ажээ.

Хэрэв эрт дээрээс улстөрийг танин мэдэхэд ихэнх тохиолдолд улстөрийн үзэгдлүүдийг судлахдаа тэдгээр нь нийтийн сайн сайхан, шударга ёсны хэм хэмжээ, эсвэл аль нэг сэтгэгчийн боловсруулж томьёолсон ямар нэг улстөрийн төгс байгууламжид нийцэж тохирч байгаа эсэхийг авч үздэг үнэлэмж-хэм хэмжээний хандлага зонхилж ирсэн бол одоо улстөрийн хүрээг судлах хамгийн зохистой арга бол хатуу формальчлагдсан, гол төлөв тоон аргууд байх болно гэж үзжээ. Мөн түүнчлэн судалгаа шинжилгээний ололт, үр дүн шууд ашгаа олж байх

шаардлага тавигдах болжээ. Ийм учраас улстөр судлаачдын хүчин чармайлт аливаа онолын бүдүүвч зохиоход бус гагцхүү практик тодорхой зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдэх ёстой хэмээн тооцож байв.

Энэхүү арга хандлагыг 1920-иод онд Чарльз Мерриамын үндэслэсэн Чикагогийн улстөрийн шинжлэх ухааны сургуулийнхан улстөрийн судалгаанд эхлээд ашигласан юм. Чухам энд тоон арга, судалгааны техникийг туршиж эмпирик судалгааны хөтөлбөрүүдийг анх удаа боловсруулж хэрэгжүүлжээ. Эдгээрийг тус хотын сонгогчдын үйл байдал, оршин суугчдын бүлгүүдийн хүн ам зүйн шинж төлөв, сонгогчдын саналд ухуулга сурталчилгааны үзүүлэх нөлөөлөл зэргийг судлах явцдаа амжилттай туршиж хэрэглэсэн байна. Чикагогийн сургуулийн шинэлэг тал нь улстөрийн бодит байдлыг судлахдаа эмпирик судалгаа нарийн оновчтой, дүгнэлт нь үнэмшилтэй байхыг шаардаж, судалгааны үр дүнг тооцоолохдоо статистик нарийвчлалтай техник хэрэглэхийг нэвтрүүлсэнд оршдог. Үүгээрээ улстөрийн шинжлэх ухаанд ихэвчлэн хэрэглэгдэж ирсэн түүхийн, философийн, хууль эрхийн арга зүйг өөрчилж эмпирик арга, квантификацийг оруулж ирэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Энэ сургуулийн гол төлөөлөгчид Г.Госнелл, Г.Лассуэл улстөрийн судалгааны сэтгэл зүй, социологийн хандлагыг баримтлагчид учир улстөрийн үзэгдлүүд, үйл явцыг улстөрд оролцогч хувь хүмүүсийн сэтгэл зүйн онцлог, тус тусын ашиг сонирхлоо мөрдлөг болгосон хэсэг бүлгүүдийн харилцан үйлчлэлээр тайлбарлаж байв. Жишээ нь, Лассуэл “Дэлхийн I дайны үеийн суртал нэвтрүүлгийн техник” (1927) анхны номондоо улстөрийн коммуникацийг авч үзсэн бол хоёр дахь ном “Сэтгэцийн эмгэг ба улстөр”-дөө (1930) улстөрчдийн намтарт дүн шинжилгээ хийх замаар улстөрийн сэтгэл зүйн судалгаагаа гүнгийрүүлж, “Дэлхийн улстөр ба Хувь хүний айдас” (1935) гуравдахь номдоо хувь хүний улстөрийн үйл байдал, улстөрийн өөр өөр дэглэмүүдийн сэтгэл зүйн үндэс, илрэх шинжүүдийг судалсан бол “Улстөр: хэн юуг хэзээ хэрхэн олж авах нь” (1936) дөрөвдэх номдоо улстөрийн үйл явц бол орлого, нэр хүнд, аюулгүй байдал гэх мэт үнэт зүйлсийн төлөө элит бүлгүүдийн хоорондын тэмцэл гэсэн байр сууринаас улстөрийн ерөнхий онолыг товч тодорхой хураангуйлан тайлбарласан ажээ.

Чикагогийн сургуулийн эрдэмтэд шинжлэх ухааны бусад сургуулиудын төлөөлөгчидтэй нягт холбоотой ажилласнаар улстөр судлалд салбар хоорондын судалгааны эхийг тавьсан гэж үздэг. Гэхдээ энэ сургуулийг үндэслэгчид, тухайлбал Мерриам улстөрийн шинжлэх ухаанд бусад шинжлэх ухааны оруулж буй хувь нэмэр нь уг шинжлэх ухааныг хэт хялбарчилж, улстөрийн үзэгдлүүдийг бусад шинжлэх ухааны ойлголтоор тайлбарлахад хүргэж болзошгүйг сануулж байсныг бас бодууштай. Чикагогийн сургуулийн уламжлал тасарч алга болоогүй бөгөөд харин ч олон улс судлал, харьцуулсан улстөр, сонирхлын бүлэг, улстөрийн нам, сонгуулийн үйл явц, олон нийтийн санаа бодлын судалгаа зэрэг улстөрийн мэдлэгийн хүрээг хамран өргөжсөн байна. Энэ бүхнээс үзэхэд өрнөдийн улстөр судлалд хувьсгал хийсэн гэгддэг бихевориал арга зүйн хандлага чухам эндээс эх авсан нь илэрхий байна. Бихевориал хувьсгалын гол ололт нь улстөрийн институцийг судлахаас улстөрийн үйл явцыг, албан ёсны институцийг

судлахаас албан бусыг, хууль эрхийн судалгаанаас (легализм) бодит байдлын шинжилгээнд (реализм) шилжсэнд оршиж байсан гэж дүгнэж болох юм. Учир нь энэ үед улстөрийн шинжлэх ухаанд институциональ хандлага ноёрхож гол анхаарал улстөрийн институци, тэдгээрийн шинж чанар, янз бүрийн улстөрийн системүүдэд тэдгээрийн эзлэх байр суурь, үүрэг роль, үүсэл мөхлийн шалтгаан зэрэгт төвлөрч байв. Үүний хамт юуны өмнө улстөрийн институтүүдийн үйл ажиллагааны хууль эрхийн тал, тэдгээрийн түүхэн хөгжил, оршин тогтнолын дотоод зүй тогтол, улстөрийн шийдвэр батлах дүрэм журам, албан ёсны бүтцүүдийн үйл ажиллагааны зарчмууд зэргийг задлан шинжлэхийг зорьж байжээ.

Хэрэг дээрээ улстөрийн үйл явц дахь хувь хүний хүчин зүйлийг төдийлөн анхаараагүй эл хандлагын хариу болж улстөрийн судалгааны шинэ стратеги гарч ирсэн нь бидний дээр дурдсан бихевораль арга зүй байсан бөгөөд үүний дүнд албан ёсны институцийн судалгааг үйл байдлын онолын янз бүрийн хувилбарууд шахаж эхэлжээ. Үүний эхлэл болж, 1944 онд П.Лазарсфельд зэрэг Колумбийн их сургуулийн эрдэмтэд сонгуулийн анхны академик судалгааны дүнгээ хэвлүүлж түүндээ хувь сонгогчдод анхаарлаа хандуулжээ. Энэ судалгааны онцлог нь хувь хүний улстөрийн үнэлэмж, ухамсар, итгэл үнэмшилд дүн шинжилгээ хийхийг чухалчилсан бөгөөд уул хандлага олон жилийн турш улстөрийн үйл байдлыг судлах чиглэл болж өгчээ. Гэхдээ үйл байдлын төрлүүд дотроос сонгогчдын үйл байдалд онцлон анхаарч, тухайлбал, сонгогчид хэрхэн, юуны учир саналаа өгч байгааг судална гэсэн үг. Үйл байдлын олон хүчин зүйл, хувьсах хэмжигдхүүнүүд, коэффициентүүдийг ашигласан судалгааны техник ч их өөрчлөгдсөн байна.

Дайны дараахь жилүүдэд Вебер, Дюркгейм зэрэг европын социологийн онолчдын бүтээлд тулгуурлаж Талкотт Парсонс, бусад эрдэмтэд (Шилс, Смелзер) нийгэм, институцийн өөр өөр хэв маягуудыг харьцуулж тайлбарлахдаа “систем”-ийг үндэс болгосон байна. Үүнд тулгуурлан Давид Истон анх удаа “систем” хэмээх ойлголтыг улстөрийн шинжлэх ухаанд оруулж ирсэн юм. Истоны улстөрийн системийн онол улстөрийг судлах, улстөрийн системүүдийг харьцуулахад судлаачдад түлхүүр арга зүй болсон төдийгүй олон талтай, ойлгоход ээдрээ төвөгтэй улстөрийн ертөнцийг хэдхэн тооны аналитик ойлголтуудад нэгтгэн зангидаж бүдүүвчид буулган тайлбарласан нь танин мэдэхүйн практик ач холбогдолтой болсон юм. Нөгөө талаас шинжлэх ухааны ойлголт ухагдхуунуудыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болжээ. Түүний онол улстөрийн системийн “эквиллибрум”-ийг хэт шүтсэн гэдэг шүүмжлэлийг харгалзан америкийн эрдэмтэн Г.Алмонд функционал онолоо санал болгосон гэж болно. Тэд улстөрийн функцийг гурван төвшинд ялгаж “системийн функцийг” “үйл явцын функцээс”, “бодлогын функцийг” энэ хоёроос тус тус ялгавартай авч үзжээ. Нийгэмшил, сонгон сэлбэлтийн үүргүүд улстөрийн системийн бүтэц, соёлыг төлөвшүүлдэг бол улстөрийн үйл явц ашиг сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх, бодлого болговьсруулах, хэрэгжүүлэх, шүүхийн журмаар хянан хэлэлцэх гэсэн таван үйл ажиллагааг багтаана. Улстөрийн систем дайчлах, хуваарилах, зохицуулах болон билэгдлийн үйл ажиллагаагаар дамжуулж дотоод, гадаад орчинтой харилцан үйлчилнэ. Коммуникацийн функци гурван төвшин бүрт, төвшингүүдийг хооронд нь, бас

улстөрийн систем ба түүний гадаад орчныг хооронд нь холбож өгдөг. Энэ бол функционал онолын гол агуулга юм.

50-иад оноос Америкийн Харьцуулсан улстөр судлалын хорооноос Л.Пай, Ж.Колеман, Д.Растоу зэрэг нэрт эрдэмтдийг оролцуулсан хөгжиж буй бүс нутгуудыг харьцуулан судлах төсөл хэрэгжүүлжээ. Энэхүү судалгааны арга зүйн үндэс нь бүтэц-үүргийн арга болсон нь улстөрийн харьцуулсан судалгааны хамрах цар хүрээг өргөтгөж, харьцуулсан аргыг хэрэглэх онолын үндэслэл, арга зүй, техникийг боловсронгуй болгохыг шаардаж улмаар харьцуулсан улстөр судлалын шинэ дэд салбар хөгжих үүд хаалгыг нээж өгчээ. Үүний хамт харьцуулсан улстөрийн түүх нь төр, улстөрийн институтууд, төрийн бодлого, гадаад бодлогын онолд чухал хувь нэмэр оруулж байв. "Case Study" арга зүйг нарийвчлан боловсруулжээ (Х.Экстейн, А.Лейпхарт). Харьцууллын арга зүй цаашид Алмонд, Колеман (1960), Пржеворски, Тюне (1970), Смелзер (1976) Доган, Пеласси (1990), Коллиер (1993), Верба (1993) зэрэг эрдэмтдийн бүтээлд үргэлжлэн боловсрогджээ. Р.Роговски харьцуулсан улстөрийн онцлогыг хоорондоо харилцан холбоо бүхий таван хандлагаар тодорхойлсныг дурдвал, улстөрийн эдийн засгийн асуудалд гойд анхаарах болсон; дотоодын улстөрийн бодлого, институтуудийн олон улсын учир холбогдлыг тайлбарлахыг сонирхох болсон; сонирхлын бүлгүүд, тэдгэрийг корпоратизмын олон дүрсүүдтэй холбож авч үзэх болсон; төрийн бүтэц тэдгээрийн гүйцэтгэх үүргийг судлах нь сэргэсэн; үндэсний үзэл, үндэстэн угсаатны зөрчил мөргөлдөөнийг судлах нь идэвхжсэн байна. Харьцуулсан улстөрийн дэд салбар хөгжсөн нь улстөрийн шинэ онол, арга зүй боловсрогдох хөрс суурь, тэдгээрийг холбох гүүр болж өгсөн гэж болно.

Үүний нэг тод жишээ нь хөгжлийн онол (Developmentalism), түүний дотор модернизацийн онол бөгөөд түүний үүсэл нь уламжлалт ёс ба орчин үеийн рациональ ёсны эрс ялгаврын тухай Макс Веберын үзэл санаатай олон талаар холбоотой юм. Улстөрийн системүүдийг харьцуулж судлах явцад модернизацийн ойлголтыг "орчин үеийн" улстөрийн институтуудын үүсэлтэй, тухайлбал, рационал бюрократ, улстөрийн төлөөлөл, бас ардчилалтай холбож авч үзсэн байдаг. Ийнхүү бүтэц үүргийн хандлага модернизацийн онолтой хүч нэгдэж хосолсон нь Гуравдахь ертөнцийн орнуудыг харьцуулахад нааштай нөлөөлжээ. Уул судалгааны үр дүн болж Л.Пай "Коммуникаци ба улстөрийн хөгжил", Дж.ЛаПаломбара "Бюрократ ба улстөрийн хөгжил", Э.Шилс "Шинэ улсуудын улстөрийн хөгжил", Д.Аптер "Модернизацийн улстөр" гэх мэт үнэ цэнэтэй олон бүтээл гарсан байна.

Үүний зэрэгцээ модернизацийн онолыг сөрж хараат байдлын онол (Dependency Theory) гарч ирсэн бөгөөд түүний үндэслэгээ нь модернизацийн онол америкийг цорын ганц загвар болгосон, ялангуяа Латин Америкийн бүс нутаг, хөгжиж буй орнуудад нэвтэрсэн үндэстэн дамнасан корпорацууд эдийн засгийн зарим "орчин үежсэн" сектор, нийгмийн давхаргыг бий болгохоос хэтэрдэггүйгээс нийгэм бүхэлдээ уламжлалт хэвээр үлддэг, тэдгээр секторын тусламжтайгаар үеэ өнгөрөөсөн хэвшлийг хадгалж, улс орны хөгжлийг боогдуулж, мөлжлөгийг

өөгшүүлж байдаг гэсэн шүүмжлэлээр илэрдэг. Иймд эцэстээ “хараат байдал” нь ардчиллыг бус харин улстөрийн харгис бурангуй дэглэмийг тогтооход хүргэж байна гэж үзжээ. Модернизацийн онолын социалист хувилбарууд ч гарсан. Тэдгээр нь хэдийгээр “модернизаци” гэсэн нэр томъёог төдийлөн хэрэглэдэггүй боловч түүнийг уг чанартаа нийгмийн хөгжлийн доод шатнаас орчин үеийн аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй социалист нийгэмд шилжих явдал гэж үздэг. Социалист модернизацийн онолуудын хэд хэдэн чиглэл байдаг бөгөөд тухайлбал, ази-африк, латин америкийн зарим хэсэгт өргөн дэлгэрсэн үндэсний социализмын үзэл баримтлалууд, социалист бүтээн байгуулалт бол буурай хөгжилтэй орнуудыг модернчлах нэг хувилбар гэж үздэг конвергенцийн өрнөдийн онолууд, ЗХУ болон социалист орнуудад боловсруулсан капиталист бус хөгжлийн замын болон социалист чиг баримжаатай хөгжлийн үзэл баримтлалууд, Хятад, Вьетнам, Лаос зэрэг орнуудын зах зээлийн социализмын онолуудыг нэрлэж болно.

Бихевориаль арга зүй болон харьцуулсан улстөрийн хүрээнд 50-иад оны дундуур улстөрийн соёлын үзэл баримтлалыг Г.Алмонд дэвшүүлэв. Тэрбээр улстөрийн үзэгдлийг сэтгэлзүй талаас судалсан Чикагогийн сургуулийн уламжлал, Вебер-Парсонсын нийгмийн өөрчлөлтийг соёлын субъектив хүчин зүйлтэй холбоосон социологийн онолд тулгуурлаж, улстөрийн соёл улстөрийн институтууд, тэдгээрийн үйл хөдлөлд нөлөөлдөг, улстөрийн соёл нь сэтгэл зүй талаас харилцан ялгавартай чиг баримжаануудаас бүрддэг, мөн улстөрийн оролцоотой нягт шүтэлцээтэй гэсэн чухал үндэслэлүүдийг гаргаж тавьсан. Нийгэм –улстөрийн хөгжлийн үйл явц харилцан уялдаатай учир аж үйлдвэржилт, хотжилт, коммуникаци, бюрократлал, орчин үеийн боловсролын нөлөөгөөр оролцооны, прагматик, плюрал улстөрийн соёл болох иргэний соёл хөгжингүй ардчилсан нийгмүүдэд зонхилж байна гэж дүгнэжээ. Ийнхүү иргэний соёлын онолоор бол тогтвортой ардчиллын үндэс нь “холимог улстөрийн соёл” байх ажээ. Улстөрийн соёлын онол, эмпирик судалгаа цаашид Л.Пай (1962,1985), С.Верба (1987), Верба, Най, Ким (1977), С.Барнес (1979), Р.Инглехарт (1977,1990), Р.Путнам (1973,1993) нарын зохиол бүтээлд үргэлжлэн тусгалаа олсон байна.

Улстөрийн шинжлэх ухаанд гарсан бихевораль хувьсгалын нэг ололт бол улстөрийн үйл явц, улстөрийн үйл байдлыг хувь хүний ашиг сонирхолдоо тулгуурласан рациональ сонголттой холбож эдийн засгийн ойлголтуудаар дамжуулан тайлбарладаг “формал онол”, “позитив онол”, “нийтийн сонголтын онол”, хамтын сонголтын онол” гэх мэт янз бүрээр нэрлэгддэг рациональ сонголтын онол (Э.Даунс, К. Арроу, Ж.Буканан, М.Олсон) улстөрийн судалгаанд олон хувилбараар түрж орж ирсэн явдал юм. Эдийн засгийн арга, загваруудыг сонгууль, хууль тогтоох хурал, түүний байнгын хороод, сонирхлын бүлгийн онол зэрэг улстөрийн сэдвүүдийг задлан шинжлэхэд анх удаа хэрэглэсэнээрээ онцлог байв. Энэ онол эдийн засгийн үйл байдлыг улстөрд оролцогч хүний үйл байдалтай мөн чанараараа адил гэдэгт судлаачдын анхаарлыг төвлөрүүлж, засаглал хийгээд шийдвэр гаргах үйл явцад ч хувь хүн эдийн засгийн амьдралд оролцдогийнхоо нэгэн адил рациональ ханддаг гэдгийг үндэс болгожээ. Өөрийн гэсэн ашиг сонирхол бүхий хувь хүний идэвхтэй үүрэг ролийг судалгааны төвд тавьж, хувь

хүний хийгээд нийт нийгмийн асуудлаар шийдвэр гаргахад хувь хүний бие даасан байдлыг хадгалах үүднээс хувийн үйл байдал, улстөрийн институтүүдийн шүтэлцээг нээж харуулахыг зорьдог нь эл хандлагын онцлог гэж болно.

Зарим эрдэмтэд формал рационал онолыг кумулятив улстөрийн шинжлэх ухаан хөгжих урьдач нөхцөл үзэх нь ч бий. Рациональ сонголтын онол улстөрийн шинжлэх ухааны шинэ салбар улстөрийн эдийн засгийн хөгжилд онол-арга зүйн чухал нөлөө үзүүлсэн нь ойлгомжтой. Ер нь үйл байдлын судалгааны хүрээнд Баруунд үүсч тэрлэсэн эдийн засгийн ойлголтуудыг хэрэглэж улстөрийн үйл явцыг тайлбарладаг улстөрийн эдийн засгийн сургууль, хувь хүний улстөрийн итгэл үнэмшил, ухамсарт нийгмийн орчны нөлөөллийг шинжилдэг улстөрийн социологийн сургууль, улстөрийн төсөөлөл, үнэлэмжид улстөрийн шийдвэр, хэвлэл мэдэээлийн нөлөөллийг судалдаг улстөрийн сэтгэл судлалын сургууль гэсэн гурван чиглэл аажимдаа ойртож улстөрийн үйл байдлыг судлах зорилт, зарчмуудын талаар зөвшилд хүрсэн байна. Чингэхдээ хэрэгцээ сонирхлынхоо дагуу чиглэл зорилготой үйлдэл хийж буй иргэн гэж хэн байх вэ гэдгийг томъёолохдоо хувь хүний төдийгүй нийгмийн хүчин зүйлсийг харгалзах, хувь хүнд нөлөөлөх нийгмийн нөхцлөөс гадна хувь хүний зорилгодоо хүрэх арга, боломжийг голлон судлахад анхаарах нь зүйтэй гэж үзжээ.

70-аад оны дундаас бихевориаль хандлагатай өрсөлдөж өрнөдийн улстөр судлалд нэгэн шинэ хандлага гарч ирсэн нь неоинституционализм юм. Эрдэмтэд институцийн судлагааг дахин сэргээж улстөрийг мөн л институцийн инженерчлэл утгаар авч үзэх санаа дэвшүүлэв. Энэ нь хувь хүний гэхээсээ нийтлэг түгээмэл шинжийн талаас хандах нь илүүтэй сонирхол татах болж, энэ нь улстөрийн судалгаа шинжилгээнд логик-математикийн аргууд нэвтрүүлэх, түүнчлэн үйл явцыг улстөрийн эдийн засгийн боловсруулсан арга хандлагаар тайлбарлах нь нэмэгдсэн байна. Ийнхүү өнгөрсөн зууны сүүлийн хагаст институциональ ба үйл байдлын хандлагууд зэрэгцэн оршсоор байсан төдийгүй бие биедээ нөлөөлж, үзэл санаа, судалгаа шинжилгээний арга аргачлалаа харилцан солилцож ирсэн нь илэрхий байна.

XX зууны улстөрийн шинжлэх ухааны хөгжлийн тухай ярихад онолын улстөр судлал, улстөрийн философийн талаар дурдахгүй өнгөрөх аргагүй. Улстөрийн онол, философийн Европын уламжлал хэдэн зууны түүхтэй, энэ утгаараа уг асуудал хэзээ ч анхаарлын гадна хоцорч байсангүй. Харин америкийн улстөрд бол “позитив” мэдлэгийн төлөө тэмцлийн явцад улстөрийн философи, ер нь л онолын танин мэдэхүйг олон жилийн турш төдийлөн ойшоож үздэггүй байснаас улстөрийн онол, улстөрийн философи улстөрийн мэдлэгийн зах хязгаар хавиар “нутагтай” байсан нь үнэн юм. Тийм ч учраас тодорхой, хавсарга судалгаанд их төлөв ач холбогдол өгч иржээ. Гэвч 1970-аад онд энэ салбарт эргэлт гарч улстөр судлаачид улстөрийг онолын үүднээс шүүн тунгаахын зайлшгүйг, түүний үнэ цэнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, улстөрийн онол бие даасан дэд салбар болж хувирчээ. 50-иад оны сүүлчээр Л.Штрауссын “Улстөрийн философи гэж юу вэ?”, И.Берлины “Улстөрийн онол оршсоор байна уу?” өгүүллүүд нийтлэгдсэн нь

“норматив” гэсэн шалтгаанаар бараг 50 гаруй жил улстөрийн шинжлэх ухааны чанадад байсан шударга ёс, үүрэг хариуцлага, эрх чөлөөний асуудлууд судалгааны эргэлтэд орж ирсэн байна. Тэд улстөрийн сэтгэлгээ нь дан ганц институтууд, эсвэл хувь хүмүүс, хэсэг бүлгүүдийн үйл байдлын эмпирик судалгаа биш, учир нь түүнд онол-философийн хэмжигдхүүн зайлшгүй багтдаг гээд энэ нь нийгмийн сайн сайханд ямагт чиглэгддэг улстөрийн үйл хөдлөлийн уг чанараар нөхцөлдөж байдаг учраас тухайн этгээдэд аль нэгэн үнэт зүйлсийг сонгох шаардлагыг заавал тавьдаг гэсэн санаа дэвшүүлсэн байна. 1971 онд Жон Роулсын “Шударга ёсны онол” ном хэвлэгдснээр улстөрийн онол, философийн сэргэлтийн үе эхэлсэн гэж үздэг. Роулс нийгэмд оршин буй бүх улстөрийн зөрчлүүдийн гүнд ямар нэгэн үндсэн суурь асуудлууд байх бөгөөд тэдгээрийг шийдвэрлэхийн төлөө улстөрийн философи байдаг. Чухамхүү үүний ачаар улстөрийн хамтын ажиллагаа, зөвшилцөл бололцоотой болдог. Үнэн нь шинжлэх ухааны системийн хувьд хамгийн чухал зүйл байдгийн нэгэн адил шударга ёс нь нийгмийн байгууллагуудын (институт) хувьд тэргүүн зэргийн зайлшгүй зүйл мөн болно гэсэн дүгнэлт хийжээ. Нэрт улстөрийн философч Р.Нозик Роулсын онолыг шүүмжлэхийн хамт “Роулсын шударга ёсны онол бол улстөрийн болон ёс зүйн философийн чигэлийн хүчтэй, гүн гүнзгий, түгээмэл өргөн агуулга бүхий системтэй бүтээл бөгөөд хэрэв харьцуулж болдогсон бол Жон Стюарт Миллээс хойш түүнтэй дүйцэх зохиол гараагүй билээ... Улстөрийн философчид одоо нэг бол Роулсын онолын хүрээнд ажиллах, эс тэгвээс яагаад үгүй гэдгээ тайлбарлах хэрэгтэй боллоо” гэж үнэлсэн байдаг. Роулсын үзэл санаа шинжлэх ухааны нийгэмлэгийн дотор өргөн хэлэлцүүлэг өдөөсний дүнд улстөрийн онолын судлагдхуун, эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаар эрдэмтдийн үзэл бодол улам ойртжээ. Нэг талаас улстөрийн үзэгдлүүдийн мөн чанарыг танин мэдэх философи- онолын төвшинг сэргээх, нөгөө талаас улстөрийн философи өөрөө өөрийн оюун санааны үндсүүд, байр сууриа дахин хянаж үзэх шаардлага тулгарч байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Улстөрийн философи ба онол улам бүр улстөрийн шинжлэх ухааны эмпирик судалгааны ололтод тулгуурлах хандлагатай болсныг судлаачид тэмдэглэх байна.

Түүнчлэн өрнөдийн орчин үеийн улстөрийн сэтгэлгээнд, ялангуяа эх газрын улстөрийн философид М.Хоркеймер, Т.Адорно, Х.Маркузе нарын үүсгэсэн Франкфуртын сургуулийн неомарксист, салбар дундын, нийгмийн онолоороо эрдэмтдийн анхаарал сонирхлыг ихээхэн татаж ирснийг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй. Энэ сургууль капитализм, зөвлөлт социализмыг аль алиныг нь шүүмжилж, нийгмийн хөгжлийн альтернатив замын боломжыг үндэслэхийг оролддог. Уламжлалт марксизмыг зарим талаар нөхөхийн тулд антипозитивист социологи, психоанализ, экстенциал философи зэрэг сэтгэлгээний бусад сургуулиудаас хариу эрэлхийлж, Кант, Гегель, Фрейд, Вебер нарын үзэл санааг синтетик байдлаар авч үзэхийг эрмэлздэг. 60-аад оноос хойшхи энэ сургуулийн гол төлөөлөгч Юрген Хабермас нэг талаас онолын нийгмийн ухаан, нөгөө талаас философи үндсийн хоорондын харилцааг нягтлан судалж, энэ хоёрыг хослуулах нь тайлбарын, практик, норматив чадамжийг зэрэг агуулсан байх ёстой гэж үзжээ.

Тэрбээр шүүмжлэлт онолдоо орчин үеийн төр ардчилал, соёлын адилсал, асуудлыг рациональ шийдвэрлэх шаардлагыг нэгэн зэрэг хүлээн авч чадахгүй байгаа нь дотоод хямралын шалтгаан болж байна гэж дүгнэсэн байх жишээтэй. Түүний коммуникатив үйлдлийн онол өнөө үеийн улстөрийн амьдралын олон чухал асуудлуудыг философийн үүднээс тайлбарласан байна.

Дайны дараа эрдэмтэд Францын III бүгд найрамдах улс, Веймарын улсын түүхэн сургамжийг бүр Платон, Аристотель нараас эхтэй “холимог засаглал”-ын улстөрийн онолын уламжлалд түшиглэн судалж ардчиллын талаар үзэл онолоо дэвшүүлэх болжээ. Ж.Шумпетер “сонгодог ардчиллын” үзэл санааг няцааж ардчилал бол”санал авахын төлөө элитийн өрсөлдөөн” гэж тодорхойлсон бол П.Лазарсфельд нар ардчиллыг нийгэм, соёлын тодорхой нөхцлүүдтэй холбож, үүндээ эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн олон янзын байгууллагууд, зөвшилцлийн үнэт зүйлийг оруулж байжээ. Э.Шилс аядуу үндэсний үзэл, нийтийн үйл ажилд оролцох сонирхол, үнэт зүйлс, институцийн хувьд зөвшилд хүрэх, хувь хүний эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх нь ардчиллыг тогтооно гэсэн үзлийг баримталж байв. Далийн полиархи онол ардчилал судлалд шинэ үзэл санаанууд гаргаж ирсэн төдийгүй норматив ба эмпирик онолууд хэрхэн бие биеэ харилцан баяжуулж болохыг баталсан жишээ болжээ. Х.Экстейн ардчиллын “холимог” шинжийг чухалчилж, ардчилал нь ард түмнийг төлөөлж, хүсэл зоригийг нь илэрхийлэхэд төдийгүй тэднийг захиран удирдахад хэрэгтэй гэсэн үндэслэгээ дэвшүүлж байв.

XX зуунд дэлхийн бүс нутгуудыг хамарсан улстөрийн том өөрчлөлт-модернизацийг залгаж, улстөрийн дараачийн глобаль өөрчлөлт -демократизаци (ардчиллах үйл явц) 70-аад оны дунд үеэс “давалгаалсан” гэж болох юм. Энэ хоёр үйл явц улстөрийн өөрчлөлтийн утгаараа адил төсөөтэй боловч шилжилтийн агуулгаараа харилцан өөр, тухайлбал, хоёрдахь үйл явцын үндсэн зорилго нь улстөрийн ардчилал байснаараа зарчмын ялгаатай байв. Энэ хүрээнд ардчилсан шилжилтийг судлах улстөрийн шинжлэх ухааны шинэ салбар- транзитологи үүссэн юм. Д.Растоу 1971 онд бичсэн “Ардчилсан шилжилт: динамик загварын оролдлого” өгүүлэлдээ ардчилалд шилжих урьдач нөхцөл, шилжилтийн үе шатуудын талаар үзэл баримтлалаа томъёолсон нь транзитологийн эхлэлийн цэг болсон гэж болох юм. Ардчилал судлал олон улсыг хамарч, эрдэмтэд Растоугийн үзэл санааг баяжуулан, шилжилтийн зүй тогтол, онцлог, ардчиллын бэхжилт, чанарын хэмжүүрийн талаар олон эмпирик онол, загварыг санал болгосон билээ. Олон улсын улстөрийн шинжлэх ухааны Холбооны сүүлчийн их хурал дээр тус холбооны Ерөнхийлөгч профессор Л.Морлино эдүгээ улстөр судлаачдын өмнө тулгамдаж байгаа хамгийн чухал асуудал бол ардчиллын чанарын судалгаа юм гэдгийг цохон тэмдэглэсэн нь учиртай. Ардчиллын онолын хөгжил цаашид Р.Даль (1956,1961,1966,1970,1973,1982,1985), А.Лейпхарт (1968,1984,1999), Ж.Сартори (1987), ардчиллах үйл явцын онол практикын асуудлууд Линц, Степан (1978), Даймонд, Платтнер (1993), Шмиттер, О’Доннелл, Уайтхед (1986) Хантингтон (1991) нарын бүтээлд боловсруулагдсан байна.

Дүгнэвээс ер нь аливаа шинжлэх ухааны үүсэл, цаашдын өсөлт бойжилт нь мэдлэгийн институжилт, зохион байгуулалтаас ихээхэн хамаардаг нь ойлгомжтой. Гэхдээ хамгийн гол нь тухайн шинжлэх ухааны онол-арга зүйн хөгжил юм гэж үзэж байна. Энэ үүднээс авч үзвэл XX зуунд улстөрийн шинжлэх ухааны хөгжил, онол арга зүйд гурван онцлог үе тохиосны анхных нь эмпирик судалгаа эргэлтэд орж улстөрийг социологийн болон сэтгэл зүйн өнцгөөс тайлбарласан үе (1920-1940), хоёрдах нь дэлхийн хоёрдугаар дайны дараа “бихевориаль” улстөрийн шинжлэх ухаан хөгжиж, мэргэшлийн төвшинд хүрсэн, гуравдахь нь “рациональ сонголт-хувь хүнд төвлөрсөн арга зүйн хандлага”-д математик арга, эдийн засгийн загварууд орж ирсэн гэж үзэж болох ч улстөрийн шинжлэх ухааны хөгжлийн явцад үндсэндээ нэг талаас институциональ, нөгөө талаас бихевораль (үйл байдлын) арга хандлага зонхилж иржээ.

Харин энэ хоёр хандлага улам ойртож байгаа нь улстөр судлаач эрдэмтэд арга зүйн плюрализмыг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой. Үүний мөн чанар нь улстөрийг судлах олон янзын арга хандлагууд бүгд тэгш эрхтэй, аль нэгэн судалгааны чиглэлд давуутай байдал олгохгүй байхад оршино. Плюраль зарчим улстөрийн шинжлэх ухаанд хүмүүнлэгийн болон байгалийн шинжлэх ухаанаас ойлголт ухагдхуун, нэр томьёо, арга, арга зүйг зээлдэн авах боломж нээж өгч буй. Улстөрийн шинжлэх ухаан бусад шинжлэх ухаануудтай нягт харилцан үйлчилж ирсэн нь түүний судалгаа шинжилгээний цар хүрээг өргөтгөөд зогсоогүй тодорхой хэмжээнд түүний судлагдхуун, судлах асуудлын хил хязгаарыг бүрхэгдүүлсэн талтай. Энэ бүхэн улстөрийн шинжлэх ухааныг мэдлэг ухааны бие даасан салбарын хувьд өөрийн гэсэн онцлогоо алдахад хүргэж болох юм гэсэн болгоомжлол бас ор үндэстэй юм.

Өнгөрсөн зуунд улстөрийн шинжлэх ухаанд бүтцийн мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, нэг талаас мэдлэг дагнан нарийсах замаар харьцангуй бие даасан дэд салбарууд үүсэх, нөгөө талаас мэдлэг нийлэгжиж улстөр судлалын хэд хэдэн чиглэлүүдийн уулзвар дээр шинэ дэд салбарууд бий болох үйл явц үргэлжилж ирсэн онцлогийг дурдах хэрэгтэй. Энэ бүхэн улстөрийн шинжлэх ухаан төлөвших үйл явц хараахан дуусаагүй, улстөрийн мэдлэгийн бүтцийн тухай төсөөлөл, онол-арга зүй баяжин төгөлдөржихийн хэрээр цаашдын боловсруулалт, тодотголууд хийгдэх нь зайлшгүй гэдгийг баталж байна.

Эцэст нь тэмдэглэхэд орчин үеийн улстөрийн сэтгэлгээний түүх зөвхөн өрнөдийн үзэл санаа, хандлагыг биш дэлхийн бүх бүс нутгийг хамрах ёстой нь мэдээж хэрэг. Гэвч өрнөдийн улстөр судлал хамгийн сайн судлагдсныг үгүйсгэх аргагүй. Ийм ч учраас миний бие энэ удаа уг сэдвийг сонгон авч та бүхний анхаарлыг хандуулахыг зорьсон болно. Ер нь олон улсын улстөр судлаачдын үзэж байгаагаар өрнө, дорнын улстөрийн судалгааг шинжлэх ухааны үүднээс нэгтгэн дүгнэх хэрэгцээ шаардлага он цаг улирахын хэрээр нэмэгдэж байгааг гэдгийг бид үргэлж санаж ажиллах нь чухал байна.

Abstract

The paper will give an overview of the genesis and history of the political science in organizational, theoretical and methodical perspectives and an attempt to clarify trends of the development. Despite the deep tradition of European political thinking, the contemporary political science got a rapid development in USA. In the mentioned area was created the fundamentals of the empirical political science and began the study of politics by psychological and sociological approaches, and introduced the quantification. As of other sciences, political science focuses on the theoretico-methodical aspects. Especially, have been examined the main problems of behavioralism, structural functionalism, neoinstitutionalism, modernization and, cultural and rational choice approaches. Author has concerned the place of theory and philosophy in political knowledge. The idea of 'mixed government' originated from early thinkers had been a foundation of political thoughts from generation to generation. The author has noted some of his own ideas for the questions of political science development.

Ашигласан ном зохиол

1. A New Handbook of Political Science (1996) ed., by Goodin R. and Klingemann H. Oxford.
2. Almond G., Powell B., Strom K., Dalton R. Comparative Politics. A Theoretical Framework (2000). 3th ed.,
3. Political Science: The State of Discipline II (1983) ed., Finifter A. Washington D.C.; APSA.
4. Вольф Ж. Улстөрийн философийн удиртгал. УБ., 2002.
5. Нозик Р. Анархи ёс, төр, утопи. УБ., 2007.
6. Довчин Ё. Харьцуулсан улстөр. УБ., 2008.